

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/8/НА-СТА-ОНТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: munguntsetsegz@audit.gov.mn</p>
----------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45069,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 401

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Хонгор сумын Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн сонгон шалгаруулалтад оролцсон 2 хоршоонд 99,300.0 мянган төгрөгийн зээл олгож, санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Өмнөх оны 138,082.2 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл болон тайлант онд олгосон 99,300.0 мянган төгрөгийн зээлд 7,266.6 мянган төгрөгийн хүү тооцож, зээл, зээлийн хүүгийн

4527050115

эргэн төлөлтөд 108,882.8 мянган төгрөг хүлээн авч, 135,766.0 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	352,663,290.76	360,322,527.76
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	214,404,112.70	224,556,532.70
312	Банканд байгаа бэлэн мөнгө	214,404,112.70	224,556,532.70
3121	төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах	214,404,112.70	224,556,532.70
33	АВЛАГА	138,082,178.06	135,765,995.06
335	Бусад авлага	138,082,178.06	135,765,995.06
3352	Хувь хүмүүсээс авах авлага	138,082,178.06	135,765,995.06
35	БАРАА МАТЕРИАЛ	177,000.00	
351	Түүхий эд материал		
3511	Тусгай зориулалттай материал	0.00	
3513	Эм боох материал		
354	Хангамжийн материал	177,000.00	
35410	Бичиг хэргийн материал	177,000.00	
35440	Түлш, шатах тослох материал	0.00	
3545	Барилгын засварын материал	0.00	
3546	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал		
36	НӨӨЦ БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
392	Биет хөрөнгө		
39201	Барилга, байгууламж орон сууц		
39202	Хуримтлагдсан элэгдэл		
393	Биет бус хөрөнгө		
39301	Программ хангамж		
39302	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	352,663,290.76	360,322,527.76
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	352,663,290.76	360,322,527.76
51	Засгийн газрын хувь оролцоо		
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн	0.00	0.00
512	Хуримтлагдсан үр дүн	352,663,290.76	360,322,527.76
51210	Өмнөх үеийн үр дүн	352,663,290.76	352,663,290.76
51220	Тайлант үеийн үр дүн		7,659,237.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,404,506.00	9,201,037.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,404,506.00	9,201,037.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,404,506.00	9,201,037.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,404,506.00	9,201,037.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,404,506.00	7,266,637.00
120009	Бусад орлого		1,934,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,584,035.00	1,541,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,584,035.00	1,541,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,584,035.00	1,541,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
210101	Үндсэн цалин		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		
210201	Тэтгэврийн даатгал		
210502	Хоол, хүнс		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0	0
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	0
210604	Урсгал засвар	0	0
2107	Томилолт, зочны зардал	0	0
210702	Дотоод албан томилолт	0	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,584,035.00	1,541,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,584,035.00	1,541,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0	0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0	0
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,820,471.00	7,659,237.00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,820,471.00	7,659,237.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	108,582,431.00	110,817,220.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	108,582,431.00	110,817,220.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	108,582,431.00	110,817,220.00
120	Нийтлэг татварын бус орлого	108,582,431.00	110,817,220.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	108,582,431.00	110,817,220.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	108,582,431.00	108,882,820.00
120009	Бусад орлого		1,934,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,761,035.00	1,364,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,761,035.00	1,364,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,761,035.00	1,364,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	2,761,035.00	1,364,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,761,035.00	1,364,800.00
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	105,821,396.00	109,452,420.00
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	-	-
22-226	Дотоод эх үүсвэр	-	-
223001	Бусад хөрөнгө	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл	-	99,300,000.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(99,300,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	105,821,396.00	10,152,420.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	108,582,716.70	214,404,112.70
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	214,404,112.70	224,556,532.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	345,842,819.76	-	345,842,819.76
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	345,842,819.76	-	345,842,819.76
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			6,820,471.00		6,820,471.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			352,663,290.76	-	352,663,290.76
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	0.00
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	352,663,290.76	-	352,663,290.76
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			7,659,237.00		7,659,237.00
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	360,322,527.76	-	360,322,527.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	305,058,200.00	100,664,800.00	(204,393,400.00)	33.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	5,000,000.00	1,364,800.00	(3,635,200.00)	27.3%
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	300,058,200.00	99,300,000.00	(200,758,200.00)	33.1%
230001	Эргэж төлөгдөх зээл	300,058,200.00	99,300,000.00	(200,758,200.00)	33.1%
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	300,058,200.00	110,817,220.00	(189,240,980.00)	36.9%
010001	Төрийн сан дах МХ эхний үлдэгдэл	214,658,200.00	0.00	(214,658,200.00)	0.0%
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/	85,400,000.00	108,882,820.00	23,482,820.00	127.5%
120010	Төсөвт байгууллагын өөрийн орлого /туслах/		1,934,400.00	1,934,400.00	0.0%
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		214,404,112.70		-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		224,556,532.70		-
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	-
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0%
3	Төсвийн байгууллага	-	-	-	-
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	-	-	-	-
	Удирдах ажилтан	-	-	-	-
	Гүйцэтгэх ажилтан	-	-	-	-
	Үйлчлэх ажилтан	-	-	-	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 135,765.9 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

Тайлант оны авлагын үлдэгдлээр тайлагнасан 11 харилцагч нартай авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Жилийн эцсийн санхүүгийн тайланд харилцагч нартай тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, 18 дугаар зүйлийн 18.1-д *“Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”*, 20 дугаар зүйлийн 20.2.6-д *“Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”*, УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, санхүүгийн тайлангийн аудитын “Ангилал”, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тооцоо нийлсэн акт үйлдэн бүртгэж залруулав.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант оны авлагын үлдэгдлээр тайлагнасан 11 харилцагч нартай авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	135,765.9	1	135,765.9	-	-	1	135,765.9	-	-	-	-
Дүн	1	135,765.9	1	135,765.9	-	-	1	135,765.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
.			-	-	-	-			-	-	-	-
Дүн			-	-	-	-			-	-	-	-